



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 11 дугаар сарын 22

Дугаар А/158

Баян-Өндөр сум

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит XVII хуралдааныг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1.1. “Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2023 оны хэрэгжүүлсэн ажлын биелэлтийн тухай

1.2. Үнэлэлт, дүгнэлт өгөх тухай (Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлсэн ажлын биелэлт)


1.3. Газрын харилцааны талаар 2023 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийн биелэлт, 2024 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай

1.4. Аймгийн 2023 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, аймгийн 2024 оны төсөв батлах тухай

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XVII хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

0179130390

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны
өдрийн 81/166 дугаар захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ XVII ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XVII хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

XI/23-ны дотор

Ажлын алба

2.“Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2023 оны хэрэгжүүлсэн ажлын биелэлтийн тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төслийг боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/24, XI/28, XII/01-ний дотор Аймгийн Засаг дарга С.Батжаргал

3.Үнэлэлт, дүгнэлт өгөх тухай (“Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2023 онд хэрэгжүүлсэн ажлын биелэлт) асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төслийг боловсруулж, Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/24, XI/28, XII/01-ний дотор Аймгийн Засаг дарга С.Батжаргал

4.Газрын харилцааны талаар 2023 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийн биелэлт, 2024 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/24, XI/28, XII/01-ний дотор Аймгийн Засаг дарга С.Батжаргал

5.Аймгийн 2023 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, аймгийн 2024 оны төсөв батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/24, XI/28, XII/01-ний дотор Аймгийн Засаг дарга С.Батжаргал

6.Аймгийн 2024 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж Ажлын албанд ирүүлэх;

XI/24 - ний дотор

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах

7.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох Хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

XI/28-ний дотор

Холбогдох Хороод

8.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

XI/24, XI/28, XII/01-ний дотор

Ажлын албаны даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг

АЖЛЫН АЛБА